

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2022.07.18

Мандалговь хот

## **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## **ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар батлан гаргасан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3.2-т заасан аргачлалаар хийлээ.

Аймгийн Засаг даргаас 2022 оны 2 дугаар улиралд 47 захирамжийн 53 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2022 оны 7 сарын 08-ны өдөр ирүүлсэн.

## **ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:**

Аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар улиралд хяналтад авсан 47 захирамжийн 53 заалт 85.5 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь-32, 70 хувь-17, 30 хувь-2, 0 хувь-1, ХБ-1 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 32 заалт нь нийт заалтын 61 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 17 заалт нь 32 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 4 хувийг, хэрэгжээгүй буюу 0 хувьтай 1 заалт 2 хувийг хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 заалт нь 2 хувийг тус тус эзэлсэн байна.

2022 оны 1 дүгээр улиралд гарсан захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 67.7 хувьтай байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох арга хэмжээ удаашралтай байна.

2. Хүүхдийн төлөө зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулах арга 2 улирал дараалан хангалтгүй хэрэгжиж байна. Хэрэгжилтийг эрчимжүүлэх

3. Аймгийн Засаг даргын 2022 оны 255 дугаар захирамжаар БШУГ-ын бүтэц орон тоо батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны 18 албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлөөр батлуулах

4. Иргэн Чимэдцэрэн овогтой Баяраагийн холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж хувийн хэрэг үүсгэн, асрамжийн үйлчилгээнд хамруулахаар холбогдох газарт материалыг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байгаа тул дахин хөөцөлдөх

5. Гарсан захирамжийг тухай бүр хяналтад авч, холбогдох хэлтсүүд Баримтжуулсан мэдээллийн хяналтын журмын дагуу Баримт бичиг тараасан бүртгэл хөтөлж, Чанарын менежерт бүртгэлийг хүлээлгэн өгч байх ажил хийгдээгүй тасарсан байна.

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг 3 дугаар улирлын захирамжийн хэрэгжилттэй хамт ирүүлэх

Тайлан хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн дарга

Г.Самданцоодол

Тайлан бичсэн:

Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг